



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/625

Мөрөн сум

Орон нутгийн өмчийн газрын орон
тоо, бүтэц батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377, 2023 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 312 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны А-1/1819 тоот зөвлөмжийн харгалзан аймгийн Орон нутгийн өмчийн газрын дүрмийг нэгдүгээр, газрын орон тоо, бүтцийг хоёрдугаар, газрын удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Орон нутгийн өмчийн газрын 2024 оны төсвийг аймгийн 2024 оны төсөвт тусган батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

d/zahiramj

6712011444

Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 01-ны өдрийн
А/625 захирамж 04 дүгээр хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар” (цаашид “газар” гэх) нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомж, аймгийн нутгийн удирдлагын байгууллагуудын бодлого, шийдвэртэй уялдуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний мэргэжлийн төрийн байгууллага мөн.

1.1. Орон нутгийн өмчийн газар нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Иргэний хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Концессын тухай хууль, бусад хууль тогтоомж, болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон мөрдөж ажиллана.

1.2. Энэхүү дүрэм нь газрын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалтыг тодорхойлно.

1.3. Газрын дүрмийг аймгийн Засаг даргын захирамжаар батлах бөгөөд батлагдсан дүрмийг Улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ авч, төрийн байгууллагын тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба төрийн санд харилцах данстай байна.

1.4. Газрыг Засгийн газрын шийдвэрийг үндэслэн Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, татан буулгана.

1.5. Газар нь аймгийн төсвөөс санхүүжинэ.

ХОЁР: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Аймгийн Засаг дарга нь Сангийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын бодлого зорилттой уялдуулан орон нутгийн өмчийн газрыг шууд удирдлагаар хангана.

2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь газрын бүтэц орон тоо, үйл ажиллагааны зардлын төсвийг тухайн жилийн аймгийн төсөвт тусган батлуулна.

2.3. Орон нутгийн өмчийн газар нь дараах бүтэц, орон тоотой байна. Үүнд:

2.3.1. Орон нутгийн өмчийн газрын дарга

2.3.2. Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.3.3 Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.3.4. Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн

- 
- 2.3.5. Өмчийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн
 - 2.3.6. Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн
 - 2.3.7. Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
 - 2.3.8. Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
 - 2.3.9. Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
 - 2.3.10. Нягтлан бодогч
 - 2.3.11. Архив, Бичиг хэргийн ажилтан
 - 2.3.12. Нярав, жолооч

2.4. Газрын даргыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд газрын даргын үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг аймгийн Засаг дарга баталж, дүгнэнэ.

2.5. Газрын дарга нь аймгийн Засаг даргын шууд удирдлагад ажиллах ба ажлаа аймгийн Засаг даргад тайлагнана.

2.6. Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс нь Орон нутгийн өмчийн газрыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

2.7. Төрийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд газрын даргад зөвлөх үүрэг бүхий захиргааны зөвлөлтэй байна.

2.8. Захиргааны зөвлөлийн бүрэлдэхүүнд газрын дарга, ахлах мэргэжилтэн, нягтлан бодогчоос гадна мэргэжлийн холбоо, иргэний төлөөллийг оруулж болно.

ГУРАВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО

3.1. Газрын үйл ажиллагааны зорилго нь "Төсвийн тухай" хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", Иргэний хууль, бусад хууль тогтоомж, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах, орон нутгийн өмчийн бодлого, хөтөлбөрийг боловсруулан, аймгийн удирдлагыг мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангахад оршино.


3.2. Орон нутгийн өмчийн газар нь үйл ажиллагааныхаа зорилгыг хэрэгжүүлэх стратегийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж газрын даргын тушаалаар батлахаас гадна жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг тайлагнана.

ДӨРӨВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

4.1. Байгууллагын үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд ил тод нээлттэй, хараат бус, хэмнэлттэй, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмуудад нийцсэн байна.

ТАВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

5.1 Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа нь дараах чиглэлтэй байна. Үүнд:



5.1.1 Өмчийн бүртгэл, ашиглалт, зохицуулалтын асуудлаар бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, шийдвэрийн санал, төсөл боловсруулах;

5.1.2 Бодлого, шийдвэр, эд хөрөнгийн ашиглалт, зохицуулалтын асуудлыг судлан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих;

5.1.3 Орон нутгийн өмчийн бүртгэл, хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, технологи, программ хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, салбарын мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх асуудлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх;

5.1.4 Орон нутгийн өмчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх саналаа төрийн холбогдох байгууллагад хүргүүлэх;

5.1.5 Орон нутгийн өмчийн бодлого зохицуулалтыг Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх;

5.1.6 Холбогдох хууль тогтоомжийн дагуу өмчийн бодлогын баримт бичиг хөтөлбөр, эрх зүйн актыг боловсруулж хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах;

5.1.7 Орон нутгийн төсөвт болон өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих, эд хөрөнгө бэлтгэх, бүртгэх, худалдах, актлах, шилжүүлэх харилцааг төлөвлөж шийдвэрлүүлэх;

5.1.8 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үр ашиг, төлөвлөгөө, зорилтот түвшин түүний хэрэгжилтийг хариуцах;

5.1.9 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай гэрээ байгуулах, түүний хэрэгжилтийн дүгнэх, холбогдох шийдвэр гаргуулах;

5.1.10 Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг хууль, тогтоомжийн хүрээнд мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангах;

5.1.11 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагад компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

5.1.12 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах, өөрчлөх, нэгтгэх, хувьчлах, татан буулгах асуудлыг судлах, санал боловсруулах замаар орон нутгийн өмчийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

5.1.13 Өмчийн өөрчлөлтийн бүртгэлийг хөтлөх, түрээслүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах;

5.1.14 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн байгууллагуудын санхүүгийн болон хөрөнгийн мэдээ тайланг хүлээн авч нэгтгэх, нэгдсэн тайлан боловсруулах, баталгаажуулах, танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх;

5.1.15 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, дүнг нэгтгэн тайлагнах, бүртгэлээр хяналт тавих;

5.1.16 Өөрийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах;

5.2 Хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.2.1 Орон нутгийн өмчийн талаарх хууль тогтоомж, бодлого, чиглэл, тогтоол шийдвэрийн төсөл, боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах тайлагнах;

5.2.2 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөвт байгууллагын өмч, эд хөрөнгөд хяналт шалгалт хийх, тайлагнах;

5.2.4 Өмч, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтад хийсэн хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах, шийдвэр гаргуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.3 Холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийх, дүгнэлт, санал боловсруулах;

5.2.4 Орон нутгийн өмчийн эдийн засгийн болон нийгмийн үр ашгийг нэмэгдүүлэх, сэргээн засварлахтай холбогдох бодлогыг тодорхойлж, засварлах, нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг өмчлөгч, ашиглагч байгууллагуудын төсөвт тусгуулах;

5.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хууль тогтоомж зөрчсөн этгээдийн зөрчлийг бүртгэх, зөрчил маргаантай асуудлыг төрийн хяналт шалгалтын байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, орон нутгийн өмчид учирсан хохирлыг нэхэмжлэх;

ЗУРГАА: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Газрын даргын эрх

6.1.1 Орон нутгийн өмчийн газрын бүтцэд хамаарах төрийн албан хаагчдыг хууль журмын дагуу томилох, үйл ажиллагааны үр дүнд хяналт үнэлгээ өгөх, сахилга хариуцлага тооцох, чөлөөлөх;

6.1.2 Газрын нэрийн өмнөөс бусад байгууллага албан тушаалтантай харилцах, хамтран ажиллах;

6.1.3 Хууль журмаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд тушаал, зөвлөмж гаргаж биелэлтийг хангуулах;

6.1.4 Батлагдсан төсвийг хуулийн хүрээнд захиран зарцуулах;

6.1.5 Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх;

6.2 Газрын даргын үүрэг

6.2.1 Энэ дүрмийн 3.1, 3.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааны зорилго, 4.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны зарчим, 5.1-5.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээг батлагдсан бүтэц, орон тоо, төсөвт багтаан зохион байгуулах;

6.2.2 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

6.2.3 Орон нутгийн өмчийн асуудлаар орон нутгийн удирдлагыг хуульд нийцсэн мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангах;

6.2.4 Газрын ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

6.2.5 Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг дүгнэх;

6.2.6 Газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих;

6.2.7 Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар бодлого шийдвэрийн санал, төсөл боловсруулах, ажлын тайлан, мэдээг аймгийн ИТХ, Засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах;

6.2.8 Орон нутгийн өмчийн бодлого зохицуулалт, үйл ажиллагааны явц гүйцэтгэл, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх, санал гомдлыг хүлээн авч хууль, журмын дагуу шийдвэрлэх;

6.2.9 Байгууллагын техник, технологи, материаллаг баазыг бэхжүүлэх;

6.1.10 Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

ДОЛОО: ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НИЙТИЙН ӨМЧИЙН ТАЛААРХ ҮҮРЭГ, ЭРХ

7.1. Орон нутгийн өмчит байгууллагууд нь дараахь үүрэг хүлээнэ.

7.1.1. Орон нутгийн өмчийг эзэмшиж ашиглаж буй байгууллагууд нь орон нутгийн өмчийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үр дүнг холбогдох этгээдэд тайлагнах;

7.1.2. Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх;

7.1.3. Орон нутгийн өмчийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, үр дүнтэй ашиглах бодлого, хөтөлбөртэй байх;

7.1.4. Орон нутгийн өмчийн газраас өгсөн зөвлөмж шийдвэрийг биелүүлэх, тайлагнах;

7.1.5. Хууль журмаар тогтоосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

7.2. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд нь дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.2.1. Орон нутгийн өмчийн хөрөнгийг бэлтгэх, ашиглах, захиран зарцуулах, сэргээн засварлах, актлах асуудлыг хуулийн хүрээнд зохион байгуулах;

7.2.2. Орон нутгийн өмчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гомдол гаргах;

7.2.3. Хуульд заасан бусад эрхийг эдэлнэ.

НАЙМ: БУСАД

8.1 Энэ дүрмэнд шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлтийг тухай бүр аймгийн Засаг даргаар батлуулснаар хүчин төгөлдөр болно.



АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ОРОН ТОО, БҮТЭЦ

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 312 дугаар тогтоолуудыг үндэслэн аймгийн Орон нутгийн өмчийн газрын орон тоо, бүтцийг дараах байдлаар батлав.

1. Газрын дарга-1
2. Өмчийн удирдлага хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн-1
3. Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1
4. Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн-1
5. Өмчийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн-1
6. Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн-1
7. Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн-1
8. Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн-1
9. Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн-1
10. Нягтлан бодогч-1
11. Архив, бичиг хэргийн ажилтан-1
12. Нярав, жолооч-1

Аймгийн Засаг даргын 2
кирамжийн гуравдугаар х

Аймгийн Засаг даргын 2
кирамжийн гуравдугаар х

